



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IY байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ХААГЧДЫН  
НЭГДСЭН ЭМНЭЛЭГТ

2013.02.25 № 01/11 УАГ/САГ/2013/21 СТГА

Төсвийн орлого болгох тухай

Үндэсний аудитын газрын 2012 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2012 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:

1. 2012 оны 03 сарын 26-ны өдөр “Нийгэмд стандарт хэвшүүлэх сан” ТББ-д тушаал, шийдвэргүйгээр 440.0 мянган төгрөгийг хандивласан.
2. Эмнэлгийн даргын гар утасны төлбөрт 2012 оны 01-07 сар хүртэл, 9, 11 дүгээр сарын нийт 478.1 мянган төгрөгийг төсвийн зардлаас төлсөн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 25.10-д “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно”, Сангийн сайдын 2009 оны 147 дугаар тушаалаар баталсан “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”-ын 9.1-д “Батлагдсан төсвийн хуваарь болон төсөл арга хэмжээний зардалд ... гүйцэтгэл гаргахыг хориглох...” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд “Төрийн аудитын тухай” хуулийн 15.1.12 дахь “Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар баталсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 2.1.1 дэх заалтуудыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

“Нийгэмд стандарт хэвшүүлэх сан” ТББ-д тушаал, шийдвэргүйгээр 440.0 мянган төгрөгийг хандивласан. эмнэлгийн даргын хувийн гар утасны төлбөрт зохих шийдвэргүйгээр төсвийн зардлаас төлсөн 478.1 мянган төгрөг нийт 918.1 мянган төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сангийн 900000601 тоот дансанд 2013 оны 4 дүгээр сарын 25-ны дотор төвлөрүүлж,

070929

улсын төсвийн орлого болгохыг Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн дарга Л.Зориг, Ерөнхий нягтлан бодогч Ж.Отгонням нарт хариуцуулав.

2. Тогтоосон төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч, биелэлтийг 2013 оны 4 дүгээр сарын 25-ны дотор ҮАГ-т ирүүлэхийг Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн дарга Л.Зориг, Ерөнхий нягтлан бодогч Ж.Отгонням нарт хариуцуулав.

## АКТЫГ

### ТОГТООСОН:

Үндэсний аудитын газрын

Ахлах аудитор *Г.Юра* Г.Юра

Бодит бүртгэл Аудит ХХК-ийн

Захирал *З.Ганболд* З.Ганболд



### ЗӨВШӨӨРСӨН:

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн дарга

*Л.Зориг* Л.Зориг

Ерөнхий нягтлан бодогч

*Ж.Отгонням* Ж.Отгонням

